



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2021 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 421

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эрчим хүчний яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 88,350,000.00 (наян найман сая гурван зуун тавин мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашины улсын бүртгэлийг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132007745

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн  
4 дугаар тогтоолын хавсралт

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ БАЛАНСААС  
БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл
			(төгрөг)
1	Хьюндай Игуус, 14-42 УНУ, КМНГН41СВСU045880	2011/2011	88,350,000.00
Нийт дүн			88,350,000.00
			(наян найман сая гурван зуун тавин мянган)